# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 391

Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хавсралтад заасан 76 аж ахуйн нэгж, байгууллагын 3438 гадаадын ажиллах хүч, мэргэжилтний Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл зохих журмын дагуу сунгахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын дагуу ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг хөдөлмөр эрхлүүлэх, буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд мэдэгдэхийг холбогдох сайд нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.АРИУНЗАЯА

Засгийн газрын 2021 оны 391 дүгээр тогтоолын хавсралт

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАДААДЫН АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТОО

| № | Аж ахуйн нэгж, байгууллагын нэр | Гүйцэтгэх үйл ажиллагаа | Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо |
|---|---|---|---|
| | Авто замын барилгын үйл ажиллагаа явуулах (төмөр зам, нисэх буудал) | | |
| 1. | “Сино хайдро корпорейшн монголиа” ХХК | Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлт, авто замын барилгын ажил гүйцэтгэх | 74 |
| 2. | “Чайна райлвэй твэнти бюро групп корпорэйшн монголиа” ХХК | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Замын цагдаагийн газрын ойролцоо гүүрэн гарц барих” төслийн авто замын барилгын ажил гүйцэтгэх | 47 |
| 3. | “Бээжин юни констракшн групп монголиа” ХХК | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг барих ажил, “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто зам” төслийн гүүр хоолой, БАГЦ5 хэсгийн 76 км авто замын барилгын ажил гүйцэтгэх | 77 |
| 4. | “Хейлонгжиан жиней рөүд энд бридж групп” ХХК | Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км хатуу хучилттай замын засвар шинэчлэлийн ажил гүйцэтгэх | 3 |
| 5. | “Гүйжөү хай вэй инженеринг групп монголиа” ХХК | | 24 |
| 6. | “Чайна гео инженеринг корпораци” ХХК | | 25 |
| 7. | “Монгол ЛЗ зам гүүр” ХХК | Дархан Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замын барилгын ажил гүйцэтгэх | 23 |
| | | Азийн хөгжлийн банкны МОН-3129 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө | 88 |

| | | | |
|---|---|---|---|
| | | оруулалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжих Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км асфальтбетон хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх | |
| 8. | "Чайна хуаши энтерпрайзиз" ХХК | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд Толбо сум-Хашаатын даваа чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх | 10 |
| 9. | "Эйч Кэ Би интернэшнл холдинг" ХХК | Азийн хөгжлийн банкны МОН-3129 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хүрээнд "Азийн авто замын АН-4 чиглэлийн Өлгий хотыг тойрон гарах авто зам, гүүрийн барилгын ажил гүйцэтгэх | 53 |
| 10. | "Нью улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК | Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийн төсөл хэрэгжүүлэх | 8 |
| 11. | "СССС ХК" компанийн төлөөлөгчийн газар (Чайна коммуникэшн констракшн компани) | Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто замын барилгын ажил гүйцэтгэх | 7 |
| 12. | "Шанхай констракшн групп монголиа" ХХК | Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх | 11 |
| | | Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэх (багц-4) | 73 |
| 13. | "Гуанжоу ванан констракшн супервишн" ХХК | Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замын, Улаанбаатар-Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал чиглэлийн 32.2 км хурдны авто зам барих барилгын ажлын зөвлөх үйлчилгээ, Туул гол дээгүүр Баянзүрхийн 321 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг барих барилгын ажлын зөвлөх үйлчилгээ үзүүлэх | 4 |
| 14. | "Тахилт хайрхан транс" ХХК | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын барилгын | 50 |

| | | | |
|---|---|---|---|
| | | ажил гүйцэтгэх | |
| 15. | “Бодь-Интернэшнл” ХХК | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 208.5 км төмөр замын барилгын ажил гүйцэтгэх | 73 |
| 16. | “Жунмэй инженеринг групп” ХХК | Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын барилгын ажил, “Хилийн боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл”-ийн хүрээнд Замын-Үүд болон Гашуунсухайт боомтын барилга байгууламж, дэд бүтцийн барилга угсралтын ажил гүйцэтгэх | 114 |
| 17. | “Ай Си Ти Сайн консалтинг” ХХК | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам, Толбо сум-Хашаат чиглэлийн авто замын төслүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил гүйцэтгэх | 12 |
| 18. | “Шинжиан шинфа” ХХК | Дашинчилэн-Орхон гүүр чиглэлийн замаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км авто замын барилгын ажлыг “Барих-Шилжүүлэх” концессын гэрээний ажил гүйцэтгэх | 9 |
| 19. | “Си Жи Жи Си монголиа” ХХК | Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэх | 6 |
| 20. | “Ти Ти Си энд Ти” ХХК | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэх | 10 |
| 21. | “Эн Ди Ти Кэй” ХХК | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын барилгын ажил гүйцэтгэх | 11 |
| | Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулах | | |
| 22. | “Оюутолгой” ХХК | Өмнөговь аймгийн нутагт зэсийн баяжмалын олборлолт, борлуулалт, экспорт, гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх | 300 |
| 23. | “Шинь шинь” ХХК | Дорнод аймгийн Дашбалбар суманд Улааны полиметаллын ордод олборлолтын үйл ажиллагаа явуулах | 84 |
| 24. | “Тун гуан майнз констракшн монгол” ХХК | Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт “Шинь Шинь” ХХК-ийн Улааны полиметаллын ордын олборлолтын үйл ажиллагаанд туслан гүйцэтгэгчээр ажиллах | 39 |
| 25. | “Хунюэнсинхан” ХХК | Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт “Цайрт минерал” | 51 |

| | | | |
|---|---|---|---|
| | | ХХК-ийн ордод хөрс хуулалт, ачаа тээврийн ажил гүйцэтгэх | |
| 26. | “Тефисмайнинг” ХХК | Ховд аймгийн Дарви суманд хэрэгжиж байгаа Зүүн хөшөөтийн нүүрсний ил уурхай төслийн 1.5 сая тонн хүчин чадалтай нүүрс угаах үйлдвэр барьж, ашиглалтад оруулах ажил гүйцэтгэх | 36 |
| 27. | “Болдтөмөр ерөө гол” ХХК | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт-Импорт банкны хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Ерөө суманд төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр барих, Дорноговь аймагт төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжингийн үйлдвэрийн ажил гүйцэтгэх | 145 |
| 28. | “Жөн-Юан” ХХК | Баян-Өлгий аймгийн Ногооннуур суманд далд уурхайн малталтын ажил гүйцэтгэх | 10 |
| 29. | “Лутчулуу” ХХК | Хэнтий аймгийн Дархан суманд байрлах Баргилтын төмрийн хүдрийн ордыг далд аргаар олборлох ажил гүйцэтгэх | 21 |
| 30. | “Тэн Хун” ХХК | Төв аймгийн Жаргалант суманд ашигт малтмалын MV-000713 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд Нарантолгойн алтны үндсэн ордод олборлох, баяжуулах ажил гүйцэтгэх | 20 |
| 31. | “Хун шин вэй иэ” ХХК | Төв аймгийн Жаргалант суманд Наран-толгой алтны уурхайн ажил гүйцэтгэх | 24 |
| 32. | “Чинхаш” ХХК | Дундговь аймгийн Говь-Угтаал суманд Зүүн тойрмын уурхайн баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил гүйцэтгэх | 5 |
| 33. | “Эм Эл цахиурт овоо” ХХК | Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутагт орших Цахиурт Овоогийн төмрийн хүдрийн ил уурхайн бүтээн байгуулалт “Ган, төмөрлөг боловсруулах үйлдвэрийн цогцолбор”-ын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх | 14 |
| 34. | “Эйч Эс Эйч Эс” ХХК | Төв аймгийн Заамар суманд алтны уурхайн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, засвар үйлчилгээний ажил гүйцэтгэх | 27 |
| 35. | “Ачир” ХХК | Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт нүүрс угаан, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах | 15 |

| | | | |
|---|---|---|---|
| 36. | “Төвшин” ХХК | Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт Цагаан элгэх нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар олборлох, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах | 17 |
| 37. | “Юань айф” ХХК | Өмнөговь аймгийн Цогтцэций суманд “Ёл повер” ХХК-ийн туслан гүйцэтгэгчээр нүүрс угаах үйлдвэрийн ажил гүйцэтгэх | 15 |
| | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулах | | |
| 38. | “Ананд биотехнологи” ХХК | Малын хаягдал ясыг боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах | 10 |
| 39. | “Мөнх баясах кэйсинг” ХХК | Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрийн барилгыг өргөжүүлэх, тоног төхөөрөмж шинээр угсарч суурилуулах ажил гүйцэтгэх | 20 |
| 40. | “ББ экспресс” ХХК | Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж шинээр угсарч суурилуулах ажил гүйцэтгэх | 20 |
| 41. | “Диньже” ХХК | Хүнд даацын автомашин, сэлбэг хэрэгслийн худалдаа, засвар үйлчилгээ явуулах | 18 |
| 42. | “Стандарт шуудай” ХХК | Даацын шуудай үйлдвэрлэлийн ажил гүйцэтгэх | 9 |
| 43. | “Монпактрейд” ХХК | Хуванцар сав үйлдвэрлэлийн туслах ажилтан | 1 |
| 44. | “Өлзийт тал” ХХК | Нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хороо Үйлдвэрийн бүсэд дулааны аргаар мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах | 7 |
| | Газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулах | | |
| 45. | “Петрочайна дачин тамсаг” ХХК | Дорнод аймгийн Матад сумын Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхлэх | 706 |
| 46. | “Доншен газрын тос монгол” ХХК | Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн нутагт Бүтээгдэхүүн хуваах 97 дугаар гэрээт талбайд газрын тос олборлолтын үйл ажиллагаа эрхлэх | 77 |
| 47. | “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК | Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экзим банк хооронд байгуулсан 1 тэрбум америк долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт жилд 1.5 | 144 |

| | | | |
|---|---|---|---|
| | | сая тонн газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын ажил гүйцэтгэх | |
| 48. | “Газопровод союз восток” ХХК | Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайруулан хийн хоолой барих төслийн ажил гүйцэтгэх | 14 |
| | Эрчим хүч, цахилгаан холбооны салбарт үйл ажиллагаа явуулах | | |
| 49. | “Хуавейтехноложи” ХХК | Харилцаа холбоо, интернетийн үйлчилгээ явуулж, техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэн ашиглалт үйлчилгээг хангаж, LTE төслийн угсралт, ашиглалт, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх ажил гүйцэтгэх | 8 |
| 50. | “Хунан индастриал экүйпмент инсталэйшн” ХХК | “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 35/50 мВт-ын турбогенераторыг өргөтгөх, шинэчлэх төслийн ажил гүйцэтгэх | 50 |
| 51. | “ТБЕА энержи монголиа” ХХК | Дорнод аймгийн Чойбалсангийн дулааны станцын 50 мВт-ын өргөтгөлийн ажил гүйцэтгэх | 80 |
| 52. | “Багануур пауэр” ХХК | Нийслэлийн Багануур дүүрэгт баригдах 700 мВт хүчин чадалтай “Багануур дулааны цахилгаан станц” төслийн барилгын ажил гүйцэтгэх | 7 |
| | Боловсролын салбарт үйл ажиллагаа явуулах | | |
| 53. | “БСИЖМН” ХХК | Монгол Улсын Засгийн газарт олгож буй Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжаар баригдах 5 сургууль, 1 цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэх | 11 |
| 54. | “Г.В.Плехановын нэрэмжит оросын эдийн засгийн их сургууль”-ийн Улаанбаатар дахь салбар | Оросын Холбооны Улсын боловсролын стандарт хөтөлбөрийн дагуу сургалт явуулах | 78 |
| 55. | Кириллица бага сургууль | Орос хэлний сургалттай бага сургуулийн үйл ажиллагаа эрхлэх | 5 |
| 56. | “Монгол Францын төв” НҮТББ | Франц хэл болон франц хэлтэн орнуудын соёлыг түгээн дэлгэрүүлэх, франц хэлний олон улсын шалгалт зохион байгуулах үйл ажиллагаа эрхлэх | 4 |
| 57. | Улаанбаатар дахь олон улсын дунд сургууль | Боловсрол олгох үйл ажиллагаа эрхлэх | 20 |
| | Барилгын салбарт үйл ажиллагаа явуулах | | |
| 58. | “Чайна тисижү сивил инженеринг групп” | “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих | 80 |

| | | | |
|---|---|---|---|
| | ХХК | төсөл”-ийн ажил гүйцэтгэх | |
| 59. | “Монголын алт МАК” ХХК | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Богдхан уулын Залаатын аманд “Залаат” төслийн ажил гүйцэтгэх | 134 |
| 60. | “Чайна Гэжоуба Групп Интернэйшнл” ХХК | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжаар нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд баригдах сургуулийн барилга, Архангай аймгийн Эрдэнэбулган суманд баригдах цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэх | 5 |
| 61. | “Мөнхийн баян гал” ХХК | Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт цементийн үйлдвэр эрхлэх | 25 |
| 62. | “Үйлдвэрийн барилга байгууламж корпораци” ХХК | Сүхбаатар аймагт “Цайрт минерал” ХХК-ийн Төмөртийн овооны цайрын уурхайн далангийн нуранги засах ажил гүйцэтгэх | 25 |
| 63. | “Энх арвай” ХХК | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороонд “Шинэ 100 айл” барилгын ажил, Сүхбаатар дүүргийн “Хангай хотхон” барилгын ажил, Дархан-Уул аймагт арьс ширний барилгын ажил гүйцэтгэх | 35 |
| 64. | “Вестернхолд” ХХК | Ховд аймгийн Буянт суманд “Ховд эко цемент” төслийн хүрээнд жилд 250000 тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий барилгын материалын үйлдвэрийн барилгын ажил гүйцэтгэх | 49 |
| 65. | “Алсын өртөө” ХХК | Сэлэнгэ аймгийн Мандал суманд хаягдал төмөр ашиглан арматур, ган туйвангийн үйлдвэрлэлийн ажил гүйцэтгэх | 12 |
| 66. | “Жи Эс дорнын хөгжил” ХХК | Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд хөнгөн бетон гулдмайн үйлдвэрийн ажил гүйцэтгэх | 12 |
| 67. | “Монцемент билдинг материалс” ХХК | Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт Монцемент үйлдвэрийн барилгын ажил, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд клинкер боловсруулах үйлдвэрийн барилгын ажил гүйцэтгэх | 5 |
| 68. | “Синвоюань” ХХК | Нийслэлийн Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт ган туйвангийн үйлдвэрийн ажил гүйцэтгэх | 34 |
| 69. | “Лэлметалл” ХХК | Төв аймгийн Жаргалант суманд | 15 |

| | | | |
|---|---|---|---|
| | | ашигт малтмалын олборлолтыг далд аргаар явуулах, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулах, мөнгө цэвэршүүлэх шугамыг нэмэх, хаягдлын далангийн багтаамжийг нэмэгдүүлэх ажил гүйцэтгэх | |
| 70. | “Хан тайширын оргил констракшн” ХХК | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд “BOTANIC CENTER” хотхоны барилгын ажил гүйцэтгэх | 25 |
| 71. | “Хатуутөмөр” ХХК | Дархан-Уул аймагт ган туйван үйлдвэрлэл, үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх | 10 |
| 72. | “Ойлконстракшн” ХХК | Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Рашаант өртөөнд газрын тосны бүтээгдэхүүний 50000 м$^3$ багтаамжтай 10 ширхэг ган сав, холбогдох барилгын ажил гүйцэтгэх | 6 |
| | Олон улсын байгууллагад үйл ажиллагаа явуулах | | |
| 73. | АНУ-д төвтэй “Дэзэрэт олон улсын энэрэлийн байгууллага”-ын ТББ-ын төлөөлөгчийн газар | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэргэнцэр тараах, эмч, мэргэжилтнүүдийн дунд дутуу нярайн сэхээн амьдруулах болон хараа зүйн сургалт явуулах | 20 |
| 74. | Бүгд Найрамдах Солонгос Улсад төвтэй “Копиа-Монгол” ТББ | Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран хөдөө аж ахуйн салбарт техникийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх | 2 |
| | Төрийн байгууллагад үйл ажиллагаа явуулах | | |
| 75. | Онцгой байдлын ерөнхий газар | Онцгой байдлын албанд агаараас аврах ажиллагааны нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах төсөл хэрэгжүүлэх | 12 |
| 76. | “Буянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Буянт-Ухаа спортын ордон"-ы засвар үйлчилгээний ажил гүйцэтгэх | 8 |
| | Нийт | | 3438 |